



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/146/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
БГБХН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЖДААНОУС	Жижиг Дунд Аж Ахуйн Нэгжийн Олон Улсын Стандарт



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15



1.Хараат бус аудиторын дүгнэлт

	Г ЯГААН ЦЭЭНЭ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Ч.АЗЗАЯА ТАНАА Г
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	
<small>21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203</small>	
<u>ДОА-02-23 № 127</u>	
танай _____	-ны № _____
-т	_____
Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Бусад мэдээлэл	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.</p>	
<p>Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төв нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 85,7 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.</p>	
<p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	
011020045	



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23228367.64</u>	<u>58281725.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1362855.40	8613876.16
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	4803.85	0.05
31110	Төгрөг	4,803.85	00.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,358,051.55	8,613,876.11
3121	Төгрөг	1358051.55	8613876.11
31213	Арилжааны банк дахь харилцах	1,358,051.55	8,613,876.11
3122	Гадаад валют	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
321	Үнэт цаас	0.00	0.00
33	АВЛАГА	1,875,929.14	1,875,172.88
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,875,152.67	1,875,172.17
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	776.47	00.71
35	БАРАА МАТЕРИАЛ	19989583.10	47792676.10
351	Түүхий эд материал	5227603.10	12708146.10
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	5227603.10	12708146.10
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	763,520.00
354	Хангамжийн материал	14761980.00	34321010.00
35410	Бичиг хэргийн материал	686,800.00	706,430.00
35420	Аж ахуйн материал	14,075,180.00	33,614,580.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	00.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>235620888.56</u>	<u>314461942.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	235620888.56	314461942.08
392	Биет хөрөнгө	204995888.56	283836942.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	158,573,606.56	194,741,881.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,238,524.59	-10,752,414.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,830,666.66	12,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,344,666.66	-4,097,333.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,284,600.00	125,547,767.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,865,594.34	-55,447,502.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,620,870.00	35,234,870.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,865,069.07	-13,890,325.79
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	445,867.00	445,867.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-445,867.00	-445,867.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	30625000.00	30625000.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	30,625,000.00	30,625,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>258849256.20</u>	<u>372743667.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>258849256.20</u>	<u>372743667.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	258849256.20	372743667.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	213288191.80	213288191.80
51101	Өмч: - төрийн	213,288,191.80	213,288,191.80
512	Хуримтлагдсан үр дүн	-55124521.16	58769889.86



Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	-55,124,521.16	-55,124,521.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	113,894,411.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,685,585.56	100,685,585.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	258849256.19	372743667.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356094345.80	638486697.59
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49382445.80	136422217.59
120	Нийтлэг татварын бус орлого	49382445.80	85759575.59
120009	Бусад орлого	49,382,445.80	85,759,575.59
122	Тусламжийн орлого	0.00	50662642.00
122001	Хандив тусламж /дотоод/		50662642.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	0.00
124	Зээлийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	306711900.00	502064480.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	251100300.00	442261400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251100300.00	442261400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55611600.00	59803080.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55611600.00	59803080.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	364749352.39	524592286.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364749352.39	524592286.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364749352.39	524592286.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206419174.00	291176150.00
210101	Үндсэн цалин	206,419,174.00	291,126,150.00
210104	Урамшуулал	00.00	50,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26746212.65	17956613.02
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	52,340,942.00	17,956,613.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6791446.00	8812640.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1112500.00
210302	Түлш, халаалт	3642112.00	4390200.00
210303	Цэвэр, бохир ус	1,176,000.00	1412938.00
210304	Байрны түрээс	473,334.00	1,897,002.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27554132.76	18389344.53
210401	Бичиг хэрэг	6,571,900.00	12,469,370.00
210402	Тээвэр, шатахуун	3,126,120.00	3,852,226.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,028,908.76	1,907,748.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15827204.00	160000.00
2105	Нормативт зардал	70869050.46	141761575.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70869050.46	141761575.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210604	Урсгал засвар	00.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1689000.00	1092000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,689,000.00	1,092,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221804.00	205039.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,904.00	55,904.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	88,200.00	50,328.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,700.00	98,807.64
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24458532.52	45198924.18



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,279,931.76	26,101,535.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	955,000.00	893,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,223,600.76	18,204,388.48
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8655006.59	113894411.02
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8655006.59	113894411.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	307900612.95	503614952.49
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1188712.95	1550472.49
120	Нийтлэг татварын бус орлого	1188712.95	1550472.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1188712.95	1550472.49
120009	Бусад орлого	1,188,712.95	1,550,472.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	306711900.00	502064480.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	251100300.00	442261400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251100300.00	442261400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55611600.00	59803080.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55611600.00	59803080.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	311097949.70	487960669.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311097949.70	487960669.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	311097949.70	487960669.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168587416.75	244379906.00
210101	Үндсэн цалин	168587416.75	244379906.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,340,942.09	34380475.66
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	52,340,942.09	34,380,475.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15084104.76	21956158.17
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1112500.00
210302	Түлш, халаалт	3642112.00	4390200.00
210303	Цэвэр, бохир ус	1,176,000.00	1412938.00
210304	Байрны түрээс	473,334.00	1897002.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	8,292,658.76	13,143,518.17
2104	Хангамж, бараа материалын зардал	60963774.00	161560110.30
210402	Тээвэр, шатахуун	3414760.00	3602226.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	57,549,014.00	157,957,884.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14121712.10	25684019.60
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	13,947,462.10	23,871,319.60
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	74,250.00	1,109,500.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	100,000.00	703,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-3197336.75	15654282.76
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	5747215.00	1494936.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	00.00	00.00
140003	Бусад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	5,747,215.00	1,494,936.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1377272.00	9898198.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1377272.00	9898198.00



2200	Дотоод эх үүсвэрээр	1377272.00	9898198.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	1,377,272.00	9,898,198.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	4369943.00	-8403262.00
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1172606.25	7251020.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	190,249.15	1,362,855.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,362,855.40	8,613,876.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	-55,124,521.16		258,849,256.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	-55,124,521.16	0.00	258,849,256.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	-55,124,521.16	0.00	258,849,256.20
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	-55,124,521.16	0.00	258,849,256.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	-55,124,521.16	0.00	258,849,256.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	113,894,411.02	00.00	113,894,411.02
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	58,769,889.86	0.00	372,743,667.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,711,900	307,900,613	496,581,000	487,960,670
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,711,900	307,900,613	496,581,000	487,960,670
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,711,900	307,900,613	496,581,000	487,960,670
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,250,600	206,419,174	261,162,000	291,126,150
210101	Үндсэн цалин	168,250,600	206,419,174	261,162,000	291,126,150
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,348,800	26,746,213	30,033,600	17,956,613
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,790,000	6,791,446	10,060,000	8,812,640
210301	Гэрэл, цахилгаан	1,440,000	1,500,000	2,160,000	1,112,500
210302	Түлш, халаалт	4,550,000	3,642,112	4,900,000	4,390,238
210303	Цэвэр, бохир ус	1,800,000	1,176,000	3,000,000	1,412,900
210304	Байрны түрээс		473,334	-	1,897,002
2104	Хангамж, бараа материалын зардал	16,152,500	27,554,133	7,740,000	18,389,345
210401	Бичиг хэрэг	12,120,500	6,571,900	1,320,000	12,469,370
210402	Тээвэр, шатахуун	2,400,000	3,126,120	3,900,000	3,852,226
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,632,000	2,028,909	2,160,000	1,907,749
210404	Ном, хэвлэл			360,000	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		15,827,204		160,000
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				-
2105	Нормативт зардал	72,940,800	18,289,268	101,080,100	102,579,775
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,190,800	18,289,268	100,780,100	102,579,775
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,906,200	7,628,000	59,339,100	46,382,800
210601	Багаж, техник, хэрэгсэл		6,258,000	50,939,100	34,768,800
210602	Тавилга	3,906,200	1,370,000		11,614,000
210604	Урсгал засвар			8,400,000	-
2107	Томилолт, зочны зардал	1,600,000	1,689,900	2,520,000	1,092,000
210701	Гадаад албан томилолт			-	-
210702	Дотоод албан томилолт	1,600,000	1,689,900	2,520,000	1,092,000
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	165,900	308,200	728,347
210803	Даатгалын үйлчилгээ			45,000	424,500
210804	Тээврийн хэрэгслийн татвар		55,904	64,000	55,904
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			15,000	98,808
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			-	-
210807	Газрын төлбөр		88,200	88,200	50,328
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		77,700	96,000	98,808
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,523,000	12,616,580	24,338,000	893,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000	955,000	-	893,000



	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,711,900	307,900,613	496,581,000	503,614,952
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251,100,300	251,100,300	442,261,400	442,261,400
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251,100,300	251,100,300	442,261,400	442,261,400
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,611,600	55,611,600	54,319,600	59,803,080
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,611,600	55,611,600	54,319,600	59,803,080
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,188,713	-	1,550,472
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,188,713		1,550,472
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ		0	0	0
122001	Хандив тусламж /дотоод/				0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	33	33
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	22	22	29	29
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

БГБХН тул нэмэлт дансаар гүйлгээ хийдэггүй.

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ч.Аззаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд он дамжсан авлагын үлдэгдэлтэй байгаад анхаарах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 07-ноос 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.



3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд хүндрэлгүй хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон ЖДААНОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 303,685.5 мянган төгрөгөөс тооцон 6,073.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,491.8 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 454.9 мянган төгрөгөөр буюу 4,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдлийн дансны бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,362.9	8,613.9	7,251.0
Авлага	1,875.9	1,875.2	-0.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	19,989.6	47,792.7	27,803.1
Үндсэн хөрөнгө	317,380.6	399,095.4	81,714.8



Элэгдэл	-81,759.7	-84,633.4	-2,873.7
Нийт хөрөнгө	258,849.3	372,743.7	113,894.4
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	258,849.3	372,743.7	113,894.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	258,849.3	372,743.7	113,894.4

Авлага дансны үлдэгдэл 1,875.2 мянган төгрөг болж 0,7 мянган төгрөгөөр буурсан нь Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2012 онд үүссэн, он удаан жил болсон 1,868.3 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Нийт авлагаас 1,868.3 мянган төгрөгийн эрсдэлтэй авлага байна. Энэ нь Эрдэнэс таван толгой ХХК-ны хувьцааг худалдан авахаар шилжүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй, Засгийн газраас гарах шийдвэрийг хүлээж байгаа тухай байгууллагын удирдлагаас ирсэн албан бичигт дурдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47,792.7 мянган төгрөг болж 27,803.1 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой бэлэн байдалд зориулж эм тариа, багаж хэрэгсэл авч бэлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 399,095.4 мянган төгрөг болж 81,714.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн судалгаанаас нэмэгдсэн хорогдсон шилжилт хөдөлгөөн, хөрөнгийн элэгдэл хорогдлыг тулган шалгахад ОНТХО-аар 36,168.2 мянган төгрөгийн их засварын зардлыг капиталжуулж, урсгал төсвөөс 46,382.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 10,000.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн газраас 4,494.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлогодон авч, 15,330.6 мянган төгрөгийн элэгдлээ нөхсөн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 56 тоот тогтоолоор акталсан байна.

Өр төлбөр данс нь үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 372,743.7 мянган төгрөг болж 113,894.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 282,392.3 мянган төгрөгөөр буюу 1,8 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын орлого болон хандивын орлого байна. Энэ нь нэг иргэнд ноогдох эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний дундаж зардал өссөн, улсын төсөв болон хандиваар авсан хөрөнгийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 159,842.9 мянган төгрөгөөр буюу 1,4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт цалин хөлс, норматив зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмсэн, нэг иргэнд ноогдох эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний дундаж зардал өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт



Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 496,581.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 496,581.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 496,581.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 442,261.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 54,319.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 442,261.4 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас 59,803.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 487,960.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төв нь нэмэлт дансаар гүйлгээ хийдэггүй бөгөөд орлого зарлагын нэг дансаар гүйлгээ хийдэг онцлогтой байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 12 мэдээллээс хугацаандаа оруулсан 12 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 307,849.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 255,450.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 52,399.1 мянган төгрөгийн зөрчилд 50,530.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,868.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө, өмчийн хэсгийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн хувийн өмчийн дансанд бичигдсэн 77,887.3 мянган төгрөг, эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд бичигдсэн 126,900.9 мянган төгрөг, нийт



204,788.2 мянган төгрөгийг байдлын тайлангийн цэвэр хөрөнгө, өмчийн хэсгийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн Төрийн өмчийн дансанд залруулж бичив.

2. Хандив тусламжаар авсан үндсэн хөрөнгийн орлого 50,662.6 мянган төгрөгөөр байдлын тайлангийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн төрийн өмч дансыг өсгөснийг орлого үр дүнгийн тайлангийн хандив тусламжийн орлого дансанд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй, худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй 50,530,8 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд хийсэн 50,530.8 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,868.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Худалдан авалтын е баримтыг бүрэн авч хавсаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал



Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын данснаас 1,868.3 мянган төгрөгийг Эрдэнэс таван толгой ХХК-ны хувьцааг худалдан авахаар шилжүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй, он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна.

1.2. Эрсдэл: Найдваргүй авлага үүсэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт,

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/146/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй		Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ч.Аззаяа Л.Лхамтуяа
2	Тайлант хугацаанд хийсэн 50,530.8 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	50,530.8	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ч.Аззаяа Л.Лхамтуяа
3	Байгууллагын данснаас 1,868.3 мянган төгрөгийг Эрдэнэс таван толгой ХХК-ны хувьцааг худалдан авахаар шилжүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй, он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна.	1,868.3	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Ч.Аззаяа Л.Лхамтуяа



4	204,788.2 мянган төгрөгөөр байдлын тайлангийн цэвэр хөрөнгө, өмчийн хэсгийн Засгийн газрын хувь оролцоо үзүүлэлтийн Төрийн өмчийн дансанд, 50,662.6 мянган төгрөгөөр хандивын орлого дансанд залруулга хийсэн	255,450.8	залруулсан	Дарга Нягтлан бодогч	Ч.Аззаяа Л.Лхамтуяа
ДҮН		307,849.9			